



ХЭНГИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/18

Бор-Өндөр

Цэцэрлэгийн багш ажилчдын ажлын
цагийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэхь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2, 84.4 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.3 дахь заалт, 94 дүгээр зүйлийн 94.1, 94.2, 94.3 дахь заалт, байгууллагын дотоод журмын 8.1, 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус цэцэрлэгийн ажиллах цагийн хуваарийг өглөөний 08:00 цагаас оройн 18:00 цаг хүртэл тогтоосугай.

2. Багш ажилчдын ажиллах цагийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар батласугай.

3.Батлагдсан цагийн хуваарийг 2024 оны 09 сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг нийт багш ажилчдад үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж цагийн нягтралтай ажиллахыг нийт багш ажилчдад, цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгэж сар бүрийн эцэст цагийн тооцооллолыг гаргаж баталгаажуулж ажиллахыг нярав (О.Болорцэцэг) болон жижүүрүүдэд, хяналт тавьж зөвлөн туслаж ажиллахыг арга зүйч, болон дотоод хяналтын ажилтанд тус тус үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ  И.АДИЛЖАРГАЛ

